



**ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/26

Хажуу шинэ ус

Ажлын хэсэг байгуулж зардал гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.3, 67.1.1 дахь заалт, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 24-р тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Сумын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад арга зүйгээр ханган ажиллах “Засагт хан” дээд сургуультай гэрээ байгуулж мэдээлэл, судалгаа, холбогдох материалыг цаг тухайд гарган албан байгууллагуудын дарга нарыг удирдлагаар ханган ажиллахыг Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д үүрэг болгосугай.

2. Стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Стратеги төлөвлөгөөг боловсруулах зардлын урьдчилгаа 3.000.000 /гурван сая/ төгрөгийг засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг санхүү албаны дарга (Н.Ганбат)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ө.МӨНХ-АМГАЛАН